

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙН ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 дугаар сарын 06

Улаанбаатар хот

Дугаар	ХБТББ-т тусгагдсан зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Эх үүсвэр	Нийт хөрөнгийн хэмжээ (сая төгрөг)	Суурь түвшин	Зорилтот түвшин, үр дүн (хөрөнгийн хэмжээ эх үүсвэр)			Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн хувь
								Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Төсөв (сая төг)	Төсвийн гүйцэтгэл (сая төг)		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
1	4.3.9. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно	2.Гадаадын иргэн, харьяалалгүй хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэлийн системийг үе шаттайгаар нэвтрүүлнэ.	2021-2024	Хууль зүй, дотоод хэргийн яам	Улсын төсөв	772.0	-	Үйл ажиллагаа хэвийн явагддаг болсон байна.	-	-	“Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн сан” системийг нэвтрүүлэх арга хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын улсын төсвийн хөрөнгө оруулалтын “Тоног төхөөрөмж” багцаас 470.0 сая төгрөгийг гүйцэтгэлийн дагуу санхүүжүүлэхээр 2022 онд төлөвлөн тус яамны Төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрлөөр гүйцэтгэгч байгууллагатай 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр “нууц” гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийг үндэслэн ажлын	100

											<p>даалгаврын дагуу программ хангамжийг хүлээн авснаар 2022 онд санхүүжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас 100 хувь гүйцэтгэгчид олгосон.</p> <p>“Гадаадын иргэний бүртгэл мэдээллийн нэгдсэн систем” (ISM) (одоо ашиглаж байгаа хуучин систем) дэх визийн зөвшөөрөл, виз, оршин суух зөвшөөрөл, гадаадын иргэний бүртгэл хэсгийн үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системд 10 дугаар сарын 30-ны өдрөөс бүрэн нэвтрүүлж, хүсэлтийг хүлээн авч эхэлсэнтэй холбогдуулан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тоон гарын үсгийн хэрэглээг жигдрүүлэх, шинэ систем ашиглах боломж олгох зорилгоор дээрх цахим үйлчилгээг 12 дугаар сарын 11-ний өдрөөс <a href="http://isf.mn">isf.mn</a> системээр үзүүлж</p>
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

											<p>эхэллээ.</p> <p>Цахим хөгжил, харилцаа холбооны яам, И-Монгол академитай хамтран 11 дүгээр сарын 02-ны өдрөөс танилт нэвтрэлтийн ДАН системд гадаадын иргэний бүртгэл (F-Register) ашиглан нэвтрэх үйлчилгээг “Гадаадын иргэний виз, бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан” (ISF) системтэй холбосон.</p> <p>Санхүүжилтийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас шийдвэрлэсэн тул байгууллагаас тайлагнах боломжгүй бөгөөд 2023 онд хөгжүүлэлтэд төсөв зарцуулаагүй.</p>
Үнэлгээ: 100 хувь											